



51 Page

Исаак ба Ребека

-Isaac and Rebekah-

Абрахам “Хүү минь эхнэр авах цаг нь болжээ. Хүүгээ сайн эхнэртэй болгох юмсан”

Тайлбарлагч Абрахам Исаакийг гэрлүүлэхээр болжээ. Гэхдээ Абрахам Канаан газрын охидтой хүүгээ гэрлүүлэх хүсэлгүй байлаа. Абрахамд төрсөн нутгаасаа эхнэр болох хүнийг авч өгөх санаа төржээ. Тэгээд гэрийнхээ бүх хэргийг хариуцдаг хамгийн ахмад зарцаа дуудаад

Абрахам “Чи миний нутаг болох Хараан уруу очоод Исаакт тохирох эхнэрийг олж ир. Бурхан чамайг удирдан туслах болно.”

Тайлбарлагч Зарц нь арван тэмээ болон сүйт бүсгүйд өгөх бэлэг сэлтийг аван холын аянд гарчээ.

Тайлбарлагч Үдэш болоход зарц Хараанд ирэв. Тэрээр холын аян замдаа ядран ордны гаднах худгийн хажууд суун амарч байлаа. Энэ үед худаг дээр эмэгтэйчүүд оройн хоолонд хэрэглэх усаа авахаар ирцгээжээ.

Зарц “Хаанаас эзнийхээ хүүд тохирох эмэгтэйг олох вэ байз.”

Тайлбарлагч Хөгшин зарц, яахаа мэдэхгүй байлаа. Яг энэ үед эзэн Абрахамынх нь хэлсэн үг санаанд нь оров.



52 Page

Абрахам Бурхан чамайг удирдан туслах болно гэв.

Тайлбарлагч Тэгээд зарц худгийн хажууд өвдөг сөгдөн Бурханд хандан залбирчээ.

Зарц “Бурхан минь! Ваараа тонгойлгож уснаасаа надад уулган мөн тэмээнүүдийг минь хүртэл услах, тэр охиныг Исаакт эхнэр болгох болтугай.” Та миний эзэнд хайр энэрэл үзүүлснийг тань үүгээр би мэднээ.

Тайлбарлагч Зарцыг үгээ хэлж дуусаагүй байтал, нэгэн охин мөрөн дээрээ ваартай гарч ирэв. Тэр харваас маш үзэсгэлэнтэй цэвэр охин байлаа. Тэгээд зарц хэсэг зуур харж байснаа түүнд дөхөн очоод

Зарц “Нэг аяга ус өгөөч”

Ребека Эзэн минь, Уснаас уугтун. Таны тэмээнүүдийг ч бас ханатал услаад өгье.

Тайлбарлагч Энэ үгийг сонссон зарц нь ихэд гайхжээ.

Зарц “Аа яа, Бурхан миний залбирлыг сонсчээ. Энэ охин Исаакийн эхнэр болох эмэгтэй байхнээ”

Тайлбарлагч Ингээд Исаакийн эхнэр болох эмэгтэйг олсон зарц маш их баярлаж байлаа.



53 Page



54 Page

Тайлбарлагч Тэр охиныг Ребека гэдэг байв. Зарц Ребекад бөгж, бугуйвч зэрэг гоёлуудыг бэлэг болгон өгчээ. Тэгээд түүний аавтай уулзахаар явав. Ребекагийн эцэг эх нь түүнийг маш найрсгаар угтан авав. Зарц тэр хоёрт, энэ нутагт ямар зорилгоор ирснээ ярьжээ.

Зарц “Би бол Абрахам эзэний зарц байна. Эзэн маань Исаак хэмээх ганц хүүтэй. Түүнд тохирох эхнэрийг олохын тулд энэ газарт ирлээ.”

Аав “Энэ бүх зүйлд Эзэн Бурхан тусалсан тул, охиноо танай эзний хүүтэй гэрлүүлэе.”

Тайлбарлагч: Зарц, Ребекагийн ааваас гэрлэх зөвшөөрөл авч чадав. Ребека ч хамт явна гэж хэлжээ.

Тайлбарлагч Зарц, Ребекагийн ааваас гэрлэх зөвшөөрөл авч чадав. Ребека ч хамт явна гэж хэлжээ.



55 Page

Тайлбарлагч Дараа өдрийн өглөө эртлэн босоод тэд Абрахамын амьдарч буй нутаг уруу хөдөлцгөөв. Тэднийг ирэх үед, Исаак хээр талаар явж байжээ.

Исаак “Тэр эмэгтэй хэн билээ?”

Тайлбарлагч Исаак зарц уруу чиглэн явлаа. Зарц, түүнийг ирэхэд болсон бүхнийг ярьж өгчээ. Исаак, Ребекаг дагуулан гэртээ ирэв. Тэгээд олон хүний ерөөл дотор тэд хуримаа хийцгээжээ. Энэ хоёр бие биедээ ихэд хайртай бөгөөд аз жаргалтай сайхан амьдарчээ.



56 Page